

# АРХАНГАЙ АЙМГИЙН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

## ANALYSIS ON DISASTER RISK ASSESSMENT OF ARKHANGAI PROVINCE



ᠠᠷᠬᠠᠨᠭ᠋ᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠨ ᠭᠠᠨᠠᠨᠠᠭᠤ ᠰᠤᠮᠤᠯᠠᠭᠤ ᠨᠠᠭᠤᠨ  
 UNIVERSITY OF INTERNAL AFFAIRS

### Н.Энхбаатар\*

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдал-гамшиг судлалын магистрант, ахлах дэслэгч

SR. Lt. Enkhbaatar N, MA Scholar in Emergency-Disaster Studies, University of Internal Affairs

\*Хариуцлагатай зохиогч: risk.arkhangai@gmail.com

**Хураангуй:** Эрсдэлийн үнэлгээ хийх, аюулын магадлал, түүнд өртөх эмзэг байдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэн болзошгүй аюулын сөрөг нөлөөллөөс зайлсхийх, гамшгийг хохирол багатай даван туулах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ хамаардаг. Байгалийн аливаа аюулт үзэгдэл, хүнд хэцүү саад бэрхшээлтэй тулгарч, зарим үед хүчин мөхөстөж, зарим тохиолдлыг даван туулах хөгжил, дэвшлийг бий одоо бидний амьдарч байгаа үед ирээд байна. Сүүлийн жилүүдэд байгалийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой гамшгийн тохиолдол нэмэгдсээр байгаа нь хүмүүсийн амьдарч байгаа орчинд эрсдэлийг бүрдүүлж байгаа Архангай аймгийн хэмжээнд зонхилон тохиолддог дөрвөн аюулын төрөл дээр гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг зохион байгуулж үнэлгээнд тохирсон зөвлөмжийг боловсруулан өгүүлэлд тусгалаа.

**Abstract:** This study involves comprehensive measures aimed at risk assessment, measures to reduce the probability of danger and vulnerability to it, to avoid the negative effects of potential dangers, and to strengthen the capacity to cope with disasters with less damage.

We have come to the time we are living in by creating development and progress to overcome any dangerous natural phenomena and difficult obstacles, sometimes losing strength and overcoming some cases.

In recent years, the number of natural and man-made disasters has been increasing, which creates a risk in the living environment of people. The general disaster risk assessment on the four types of hazards that are prevalent in Arkhangai Province is made and recommendations were developed in the article.

**Түлхүүр үг:** Ган, зуд, объектын гал түймэр, Ой хээрийн түймрийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ, бууруулах арга зам, зөвлөмж.

**Keywords:** General assessment of the risk of drought, fire, facility fire, and forest fire, mitigation methods, and recommendations.

### Удиртгал

Уур амьсгалын өөрчлөлт, хэлбэлзэлд өртөхгүй улс орон, бүс нутаг, аж ахуй, нийгэм эдийн засгийн салбар гэж үгүй билээ.

Гамшгаас хамгаалах тухай хуульд “Гамшгийн эрсдэл” гэж гамшгийн улмаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учирч болзошгүй хохирлын магадлалыг хэлнэ гэж томъёолсон байдаг. Иймд гамшгийн эрсдэл нь аюул, эмзэг байдлын хоорондын харилцан үйлчлэлээс бий болсон хор уршиг эсвэл гарч болох

хохирлын (хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, амьжиргааны хэрэгсэл, хүрээлэн буй орчинд хохирол учирч эсвэл эдийн засгийн үйл ажиллагаа тасалдсан) магадлал юм. (Саранцэцэг, 2024)

Ихэнх тохиолдолд объектын гал түймэр болон ой хээрийн түймрийн гол хүчин зүйл хүний буруутай санамсар болгоомжгүй байдлаас үүссэн байдаг бол зуд, гангийн аюулын хувьд байгаль цаг уурын өөрчлөлтөөс үүдэн сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай байна.





ᠬᠤᠮᠤᠰᠢᠭ ᠰᠤᠳᠤᠯᠠᠯ  
 МУНГОЛ УЛСЫН  
 ДАХЬ СӨЛӨГ  
 ШУУН СУРГАЛ  
 СУРГАЛ

Архангай аймгийн Эрдэнэбулган сум хүн амын гол цэг бөгөөд объектын гал түймрийн дийлэнх гамшиг тохиолддог бөгөөд харин цэцэрлэг, жаргалант сумууд ой мод ихтэй тул ой хээрийн түймрийн гамшиг ихэнхдээ гардаг. Гангийн гамшигийн хувьд Архангай аймаг малын тоогоор сүүлийн 2-3 жилүүдэд улсдаа эхний байруудад удаа дараа тодорсон нь сайшаалтай хэдий ч гангийн аюулыг үүсгэх томоохон хүчин зүйл нь малын хэт их тоо толгой бэлчээрийн даац хэтрэлтээс үүсэлтэй юм. Харин зудын гамшигийн хувьд цаг уурын өөрчлөлтөөс үүдэн сүүлийн 2 жил төмөр зуд, шилэн зуд, цагаанаар удархуу аюулд өртөж байгаа нь энэхүү эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийхэд оршино.

Объектын гал түймрийн эрсдэл нь зөвхөн хүн ам суурьшсан, материаллаг объект байрласан орон нутагт үүсдэг. Хот суурин газрын үерийн эрсдэл нь аюул, өртөнгө, эмзэг байдал гэсэн 3 хүчин зүйлээр тодорхойлогдох бөгөөд эдгээрийн аль нэг нь өсөх юм уу, буурахад эрсдэлийн түвшин мөн адил нэмэгдэж, буурч байдаг бөгөөд энэ нь хүн ам, хүрээлэн буй орчинд аюул учруулахуйц аюул, түүнд өртөж болох өртөнгө болон өртсөний улмаас хохирох магадлалтай нийгэм, эдийн засгийн эмзэг байдлаар нөхцөлддөг.

Зарим эрсдэлүүд түүний магадлал ба үр дагаврын аль алиныг нь ямар нэг

байдлаар багасгасан ч ноцтой байдал нь хэвээр хадгалагдаж үр дүн нь эрсдэлийг хүлээн авах түвшинд хүрэхгүй байдалтай байдаг. Эдгээр эрсдэлийн хувьд магадлал ба үр дагаврыг нь багасгах арга хэмжээ авах шаардлагагүй тул түүнээс зайлсхийх арга замыг судалж орон нутагтаа хэрэгжүүлэхэд оршино.

### Үндсэн хэсэг

Гамшигийн эрсдэлийн удирдлагын үйл явц нь эрсдэлийг тодорхойлох, шинжлэх, үнэлэх, бууруулах, хянах болон нөхцөл байдлыг тодорхойлох, харилцан хамтарч ажиллах үйл ажиллагааг тодорхой бодлого чиглэлтэйгээр цогцоор хэрэгжүүлэх гэсэн өөр хоорондоо уялдаатай юм. (Б.Баяржаргал, 2012) Гамшигийн эрсдэлийн удирдлагын үйл явц эрсдэлийн үнэлээ болон эрсдэлийг бууруулах арга хэмжээ гэсэн үндсэн хоёр хэсгээс бүрдэж, эдгээрийг хамрах хүрээ, харилцан ажиллах ба зөвлөлдөх, хяналт ба мониторингийн үйл явцаар ган, зуд, объектын гал түймэр, ой хээрийн гал түймрийн аюулыг бууруулахад оршино. (Б.Баяржаргал, 2012)

Архангай аймагт ой хээрийн болон объектын түймэр, усны осол, үер, цасан болон шороон шуурга гэх мэт гамшиг, аюулт үзэгдэл, ослоос сүүлийн 5 жилд тохиолдсон ослыг дараах хүснэгтээр харуулав.

№	Гамшиг, аюулт үзэгдэл, осол		2019	2020	2021	2022	2023
			Тоо	Тоо	Тоо	Тоо	тоо
1	Гал түймэр	Ой, хээрийн түймэр	2	13	2	3	2
2		Объектын түймэр	58	44	44	48	31
3	Ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл	Хүчтэй салхи, цасан болон шороон шуурга	4	4	6	6	18
4		Аадар бороо, үер	2	5	34	1	4
5		Зуд	0	1			
6		Аянга	1				1
7		Ган					
8	Геологийн гаралтай аюулт үзэгдэл	Газар хөдлөлт	1	1	7	2	2
9	Биологийн гаралтай аюулт үзэгдэл	Хүний гоц халдварт өвчин	Цусан суулга	0			
10			А(H1N1)томуугийн вирус	0			
11			Kovid-19 цар тахал		1	1	1

12	Мал, амьтны гоц халдварт өвчин	Тарваган тахал	0				
13		Галзуу	6	15			
14		Боом	0				
15		Хонины цэцэг	0				
16		Бог малын мялзан	0				3
17		Гахайн мялзан	0				1
18		Хар галуу үхсэн	0		8		
19		Шүлхий	0	1	14		1
20		Шувууны томуу Н5	0				
21		Хүний үйл ажиллагаатай осол	Гол, нуурын усанд унаж осолдсон	4	2	7	4
22	Химийн хорт болон аюултай бодисын алдагдал		0				
23	Зам тээврийн осол		1	1	4	2	2
24	Уурхайн осол		0				
25	Эрэн хайх дуудлага		15	6	8	5	8
Нийт тоо			94	94	123	102	76
26	Гамшиг, аюулт үзэгдэл, осол	Аварсан хүн	96	154	236	33	48
27		Аварсан хөрөнгө	1,4 тэрбум	4,5 тэрбум	2,5 тэрбум	1,5 тэрбум	3,95 тэрбум
28		Учирсан хохирол	1,3 тэрбум	13,3 тэрбум	3,5 тэрбум	0,7 тэрбум	1,71 тэрбум
29		Амь насаа алдсан хүн	7	9	50	13	9
30		Хорогдсон мал	714	71239	5391	62	1416

Хүснэгт-1. /2019-2023 оны “Архангай аймгийн”-гамшиг ослын 5 жилийн судалгаа/ Эх сурвалж. (Архангай аймаг, 2024)




Зураг-1. Ой хээр, объектын гал түймрийн тоо Эх сурвалж. (Архангай аймаг, 2024)




НҮГДЭМЖИЙН ХАМГААГАХ  
УЛАМГАЙН ХАМГААГАХ  
ТӨВӨН




ᠬᠤᠠᠨᠭᠠᠢ ᠠᠶᠢᠨᠭᠡᠨ ᠰᠤᠮᠤᠨᠢᠯᠠᠭᠤᠨ ᠰᠢᠬᠤᠮᠤᠮᠤᠯᠠᠭᠤᠨ ᠰᠤᠮᠤᠨᠢᠯᠠᠭᠤᠨ



Зураг-2. Ус, цаг агаарын гаралтай Эх сурвалж. (Архангай аймаг, 2024)



Зураг-3. Мал амьтны гоц халдварт, халдварт өвчин Эх сурвалж. (Архангай аймаг, 2024)



Зураг-4. Хүний үйл ажиллагаатай холбоотой осол Эх сурвалж. (Архангай аймаг, 2024)

МУ-ийн засаг захиргааны нэгж аймаг, нийслэл	2019	2020	2021	2022	2023
Архангай	95913	95857	94541	94146	93616

Хүснэгт-2. Архангай аймгийн хүн амын тоо Эх сурвалж: (<https://www.1212.com/>, 2024)

### Судалгааны арга

Судалгааны аргуудаас индикаторын арга нь орон нутгийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлт дээр үндэслэсэн нийгмийн тодорхой түвшний эрсдэлийг ерөнхий байдлаар илэрхийлэхэд илүү

дөхөмтэй, шийдвэр гаргах албан тушаалтнуудад гамшгийн эрсдэлийн талаарх суурь мэдээллийг бүрдүүлэхэд ашиглагдана.

Гамшгийн эрсдэлийг индикаторын аргаар тодорхойлоход аюул, өртөх байдал,

эмзэг байдал, чадавх гэсэн 4 хэсэгт хуваан авч үзнэ. Энэ 4 хэсгийг тодорхойлохдоо эдгээрийг илэрхийлэх индикатор буюу шалгуур үзүүлэлтүүдийг сонгон хэрэглэнэ.

Гамшгийн эрсдэлийг индикаторын аргачлалаар тодорхойлох ерөнхий бүдүүвчийг дараах хүснэгтээр үзүүлэв.



Үндэсний Их Сургууль  
 National University of Mongolia



Зураг-5. Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний бүдүүвч сурвалж: (Б.Баяржаргал, 2012)

Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээнд ашигласан эрсдэлийг тодорхойлсон үзүүлэлтүүдийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Индикаторуудыг индекс рүү шилжүүлж тодорхойлох утга үзүүлэлтийг “1, 2, 3” гэсэн тоон утгаар төлөөлүүлэх буюу “бага, дунд, их” гэсэн зэрэглэлд харгалзуулна.

Эрсдэлийн түвшин	Эрсдэлийн индекс	Өнгөний илэрхийлэл
Бага	0-30	
Дунд	31-60	
Их	61-100	

Хүснэгт-3. Гамшгийн эрсдэлийн төвшнийг оноо, өнгөөр тодорхойлсон байдал

Индикаторыг илтгэх индексийн утга ихсэхэд аюул, өртөх байдал, эмзэг байдлын хувьд гамшгийн эрсдэл ихсэх бөгөөд чадавхад эсрэгээрээ гамшгийн эрсдэлийг бууруулна.

$$R = (w_{HN} + w_{EE} + w_{VV}) - w_{CC}$$

(Томьёо 1)

**R**-эрсдэлийн нэгдсэн индекс(R-risk/эрсдэл),

Энэ шинж чанарт үндэслэн аюул, өртөх байдал, эмзэг байдлын индексийн утгыг нэмэх ба чадавхын индексийн утгыг эдгээрийн нийлбэрээс хасаж тооцсоноор эрсдэлийн нэгдсэн индексийг олно.

**H, E, V, C** -харгалзан аюул, өртөнгө, эмзэг байдал ба гамшгаас хамгаалах чадавхын утга (H-hazard/аюул, E-exposure/өртөнгө, V-vulnerability/эмзэг байдал, C-capacity/чадавх),

Эрсдэлийн нэгдсэн индексийг дараах томьёогоор илэрхийлж болно:

**W** - бүх үзүүлэлтүүдэд харгалзах жин буюу 0.33 гэсэн тогтмол коэффициент.

Гамшгийн төрөл	Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний үр дүн				
	Аюул	Өртөх байдал	Эмзэг байдал	Чадавх	Эрсдэл
Объектын түймэр	58	60	67	51	44.05
Ган	63	64	68	50	47.88
Зуд	65	66	71	55	48.63
Ой хээрийн түймэр	67	66	73	53	50.68
<b>Архангай аймаг</b>	<b>61.25</b>	<b>64</b>	<b>69.75</b>	<b>52.25</b>	<b>47.81</b>

Хүснэгт-4. Архангай аймгийн гамшгийн ерөнхий үнэлгээний нэгдсэн үр дүн. Эх сурвалж: (бүрэлдэхүүн, 2023)

**Зуд.** Зудын ерөнхий үнэлгээгээр нийт нутгийн 63.15% нь аюул, 94.73% нь өртөх байдал, 100% нь эмзэг байдал ихтэй

гэж тодорхойлогдсон бол 94.73% нь 50 буюу түүнээс дээш онооны чадавхтай гэж тодорхойлов.

Архангай аймгийн хэмжээнд 48,63 дүнтэйгээр дунд түвшний эрсдэлтэй байна.



ᠠᠷᠬᠠᠩᠭ᠋ᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ ᠬᠡᠮᠵᠡᠨᠳᠡ

Сумын нэр	Зуд					
	А	Ө	Э.Б	Ч	Э	
1	Эрдэнэбулган	49	57	71	54	40.59
2	Өлзийт	75	77	69	60	53.13
3	Өгийннуур	75	68	80	53	56.10
4	Батцэнгэл	67	73	71	58	50.49
5	Цэнхэр	57	72	70	58	46.53
6	Чулуут	75	75	80	56	57.42
7	Ихтамир	67	67	73	60	48.51
8	Төвшрүүлэх	73	63	72	54	50.82
9	Булган	57	62	63	58	40.92
10	Өндөр-Улаан	75	68	66	56	50.49
11	Тариат	49	66	62	51	41.58
12	Хангай	75	61	71	54	50.49
13	Цахир	64	69	67	57	47.19
14	Жаргалант	56	66	72	43	49.83
15	Цэцэрлэг	57	64	77	52	48.18
16	Хайрхан	57	66	71	57	45.21
17	Эрдэнэмандал	74	64	70	57	49.83
18	Хотонт	75	62	72	52	51.81
19	Хашаат	64	61	73	62	44.88
	<b>Архангай аймаг</b>	<b>65</b>	<b>66</b>	<b>71</b>	<b>55</b>	<b>48.63</b>

Хүснэгт-5. Архангай аймгийн зудын ерөнхий үнэлгээний дүн Эх сурвалж: (бүрэлдэхүүн, 2023)

АРХАНГАЙ АЙМГИЙН ЗУДЫН  
ЭРСДЭЛИЙН ЗУРАГ



Зураг-6. Архангай аймгийн зудын ерөнхий үнэлгээний дүн (сумдаар) Эх сурвалж: (бүрэлдэхүүн, 2023)

### Зөвлөмж:

1. Архангай аймгийн хэмжээнд аюулын түвшин өндөр үнэлэгдсэн Өлзийт, Өгийннуур, Батцэнгэл, Чулуут, Ихтамир, Төвшрүүлэх, Өндөр-Улаан, Хангай, Цахир, Эрдэнэмандал, Хотонт, Хашаат сумдад зудын аюулыг даван туулах чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд анхаарах. Тухайлбал, малчдыг мал маллах уламжлалт болон

орчин үеийн арга ажиллагаанд сургах, аймаг, сумдын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг нэмэгдүүлэх, малчин өрх бүрийн өвөлжилтийн бэлэн байдлыг хангах, малын идэш тэжээлийн нөөцийг бэлтгэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх, малчдын амьжиргааны эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд чиглэсэн төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх,

2. Бэлчээрийн нөөцийг зохистой ашиглах, отрын бэлчээрийн бүс нутгийг тогтоох, өвөлжилт хүндэрсэн тохиолдолд өөр аймаг сумдын нутагт отроор өвөлжүүлэх гэрээ хэлцлийг тогтмол байгуулах,

3. Малын индексжүүлсэн даатгалд хамрагдах малчдын тоог нэмэгдүүлэх,

4. Гамшгийн үед ашиглах санд шаардлагатай хөрөнгө мөнгийг төсөвлөж, зориулалтын дагуу ашиглах,

5. Зудын гамшгаас хамгаалах зорилгоор зудад өртөж болзошгүй малчдад эртнээс авах арга хэмжээ, тусламж, дэмжлэг үзүүлэх ажиллагааг дотоодын болон олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр зохион байгуулах,

6. Цаг агаарын мэдээг малчдад түргэн шуурхай хүргэх, мессеж үйлчилгээг

ашигладаг малчин өрхийн тоог нэмэгдүүлэх

7. Зудын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэх, төлөвлөгөөний дагуу хор уршгийг арилгах, сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах чиглэлээр сургалт, дадлага сургууль зохион байгуулах, орон нутгийн гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн анги, холбогдох талуудын чадавхыг нэмэгдүүлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах.

**Ган.** Гангийн ерөнхий үнэлгээгээр нийт нутгийн 57.89% нь аюул ихтэй, 78.94% нь өртөх байдал ихтэй, 94.73% нь эмзэг байдал ихтэй бол 57.89% нь 50 буюу түүнээс дээш онооны чадавхтай байна.

Архангай аймгийн хэмжээнд 47.88 оноотой гангийн гамшгийн эрсдэл дунд байна.



МОНГОЛЫН ИРГЭДНИЙ  
ТӨСӨВ

Сумын нэр		Ган				
		А	Ө	Э.Б	Ч	Э
1	Эрдэнэбулган	56	63	73	52	46.20
2	Өлзийт	82	65	65	59	50.49
3	Өгийнуур	75	64	72	52	52.47
4	Батцэнгэл	57	67	65	54	44.55
5	Цэнхэр	57	72	64	52	46.53
6	Чулуут	75	65	76	50	54.78
7	Ихтамир	43	68	69	48	43.56
8	Төвшрүүлэх	63	60	69	49	47.19
9	Булган	57	65	60	44	45.54
10	Өндөр-Улаан	57	67	66	45	47.85
11	Тариат	49	59	62	45	41.25
12	Хангай	65	62	73	53	47.85
13	Цахир	64	65	61	50	46.20
14	Жаргалант	56	60	66	39	47.19
15	Цэцэрлэг	67	67	67	41	52.80
16	Хайрхан	67	67	64	51	48.51
17	Эрдэнэмандал	74	55	72	49	50.16
18	Хотонт	65	61	70	51	47.85
19	Хашаат	74	67	69	62	48.84
	Архангай аймаг	63	64	68	50	47.88

Хүснэгт-6. Архангай аймгийн гангийн ерөнхий үнэлгээний дүн Эх сурвалж: (хэсэг, 2023)



АРХАНГАЙ АЙМГИЙН ГАНГИЙН  
ЭРСДЭЛИЙН ЗУРАГ



Зураг-7. Эх сурвалж: (бүрэлдэхүүн, 2023)

**Зөвлөмж:**

1. Цаг агаарын урьдчилсан сэргийлэх мэдээг орон нутгийн иргэд, малчид, тариаланчдад цаг тухайд олон арга, хэрэгслээр хүргэх,
2. Гангийн аюулын талаар иргэд, олон нийтэд сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах,
3. Гангийн аюулд өртөх нутаг дэвсгэрийн зураглал гаргах, хуурайшилтыг үнэлэх ажлыг тухайн жил бүр хийх,
4. Уур амьсгалын өөрчлөлтийн талаар мэдлэг, мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх, энэхүү өөрчлөлтөд амьдрал, ахуйгаа зохицуулан дасан зохицох чиглэлээр сургалт, мэдээлэл зохион байгуулах,
5. Малчдын бэлчээрийн даацыг сайжруулах, отор нүүдлийн зураглал гаргах, оторлох аймаг, сумын удирдлагатай гэрээ, хэлцэл байгуулах
6. Орон нутгийн нөхцөлд тохирсон ганд тэсвэртэй малын тэжээлийн ургамал,

цөлжилтийг бууруулах чиглэлээр мод, бут сөөг тарих, гүний худгийн тоог нэмэгдүүлэх ажиллагааг эрчимжүүлэх.

**Объектын гал түймэр.** Аюул үзэгдэл, ослын нөхцөл байдлын мэдээ, статистик судалгаанаас харахад Архангай аймагт тохиолдсон аюулт үзэгдэл, ослын хамгийн олон тохиолдол нь объектын гал түймэр байна.

Объектын гал түймрийн ерөнхий үнэлгээгээр Архангай аймгийн бүх сум дунд эрсдэлтэй гэж үнэлэгдсэн. 36.84% нь аюул ихтэй, 36.84% нь өртөнгө ихтэй, 94.73% нь эмзэг байдал ихтэй гэж үнэлэгдсэн. Харин чадавхын хувьд 68.42% нь 50 буюу түүнээс дээш оноотой тодорхойлов.

Аймгийн хэмжээнд аюул өндөр, өртөнгө дунд, эмзэг байдал их, чадавх дунд, нийт **44.05** буюу эрсдэлийн түвшин **дунд** гэж тодорхойлогдсон.

Сумын нэр		Объектын түймэр				
		А	Ө	Э.Б	Ч	Э
1	Эрдэнэбулган	83	70	70	56	55.11
2	Өлзийт	57	68	71	56	46.20
3	Өгийнуур	47	60	77	52	43.56
4	Батцэнгэл	65	55	67	59	42.24
5	Цэнхэр	57	57	68	55	41.91
6	Чулуут	57	65	70	53	45.87
7	Ихтамир	57	63	71	51	46.20
8	Төвшрүүлэх	40	57	69	49	38.61
9	Булган	47	53	67	52	37.95
10	Өндөр-Улаан	65	60	64	47	46.86
11	Тариат	57	63	58	48	42.90

12	Хангай	65	62	73	43	51.81
13	Цахир	47	56	63	51	37.95
14	Жаргалант	47	58	61	40	41.58
15	Цэцэрлэг	57	60	69	50	44.88
16	Хайрхан	65	60	64	56	43.89
17	Эрдэнэмандал	65	63	65	53	46.20
18	Хотонт	57	55	62	46	42.24
19	Хашаат	66	52	65	59	40.92
	Архангай аймаг	58	60	67	51	44.05

Хүснэгт-7. Архангай аймгийн объектын гал түймрийн ерөнхий үнэлгээний дүн Эх сурвалж: (бүрэлдэхүүн, 2023)

АРХАНГАЙ АЙМГИЙН ОБЪЕКТЫН ТҮЙМРИЙН ЭРСДЭЛИЙН ЗУРАГ



Зураг-8. Архангай аймгийн объектын гал түймрийн ерөнхий үнэлгээний дүн (сумдаар) Эх сурвалж: (бүрэлдэхүүн, 2023)

### Зөвлөмж:

1. Гал түймрийн аюулаас өөрийгөө болон бусдыг хамгаалах сургалт сурталчилгаа, урьдчилан сэргийлэх дадлага сургуулийг олон нийт хүүхэд багачуудад, Төр, иргэний нийгэм, аж ахуй нэгж байгууллагуудад холбогдох заавар, дүрэм журам, гал түймрээс авсан сургамжийг таниулж, ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор тогтмол зохион байгуулах,

2. Аймгийн онц чухал объектуудад гал түймрийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх,

3. Гал түймэр унтраах тактик, тархалтын дадлага, сургуулийг онц чухал объект, аж ахуй нэгж байгууллагуудад тогтмол зохион байгуулах,

4. Аймаг хэмжээнд барилга байгууламжийн гал унтраах автомат тоног төхөөрөмж дохиоллын хэрэгсэл, зарлан мэдээллийн хэрэгсэл, анхан шатны багаж хэрэгслийг суурилуулах,

5. Барилга байгууламжийн гал түймэр гарч болох аюулыг олж тогтоож, аюулгүй байдлыг хангуулах,

6. Сум, багийн төвүүдийн объектын гал түймэр унтраах чадавхыг нэмэгдүүлэх.

**Ой, хээрийн гал түймэр.** Ой, хээрийн гал түймрийн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээгээр Архангай аймгийн 73.68% нь аюул ихтэй, 89.47% өртөнгө ихтэй, нийт нутгаар эмзэг байдал ихтэй гэж тодорхойлогдсон байна. Харин чадавхын хувьд 78.94% нь 50 буюу түүнээс дээш оноотой үнэлэгдсэн байна.

Аймаг орон нутгийн нийт дүнгээр ой, хээрийн гал түймэр 50.68 оноотой ДУНД түвшинд байгаа боловч их түвшний 61 оноотой их ойрхон байгаа нь ой, хээрийн гал түймрийн эрсдэл их байгааг харуулж байна.

	Сумын нэр	Ой, хээрийн түймэр				
		А	Ө	Э.Б	Ч	Э
1	Эрдэнэбулган	55	68	70	54	45.87
2	Өлзийт	55	64	71	56	44.22



НҮГДЭМЖ  
УЛААНБААТАР  
2014



3	Өгийнуур	47	61	68	50	41.58
4	Батцэнгэл	63	59	75	59	45.54
5	Цэнхэр	81	71	73	49	58.08
6	Чулуут	71	70	86	56	56.43
7	Ихтамир	64	65	83	59	50.49
8	Төвшрүүлэх	81	62	73	54	53.46
9	Булган	81	74	76	56	57.75
10	Өндөр-Улаан	71	67	71	51	52.14
11	Тариат	81	77	67	53	56.76
12	Хангай	71	69	71	43	55.44
13	Цахир	71	62	70	54	49.17
14	Жаргалант	71	67	81	42	58.41
15	Цэцэрлэг	71	62	83	52	54.12
16	Хайрхан	47	66	72	57	42.24
17	Эрдэнэмандал	71	66	70	50	51.81
18	Хотонт	71	72	69	47	54.45
19	Хашаат	56	44	67	61	34.98
	Архангай аймаг	67	66	73	53	50.68

Хүснэгт-8. Архангай аймгийн ой, хээрийн түймрийн ерөнхий үнэлгээний дүн. Эх сурвалж: (хэсэг, 2023)

АРХАНГАЙ АЙМГИЙН ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМРИЙН ЭРСДЭЛИЙН ЗУРАГ



Зураг-9. Архангай аймгийн ой, хээрийн түймрийн ерөнхий үнэлгээний дүн (сумдаар). Эх сурвалж: (бүрэлдэхүүн, 2023)

### Зөвлөмж

1. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх зарлан мэдээллийн системийг байгуулах,

2. Орон нутгийн иргэдийн ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах, түймэр унтраах дадлага сургалтад хамруулах,

3. Сумдын ойн хээрийн түймэр унтраах чадавхыг нэмэгдүүлэх.

4. Сайн дурын бүлгэм мэргэжлийн ангийг бий болгож хээрийн дадлага, сургуулилалт хийж байх.

### Дүгнэлт

Архангай аймгийн хэмжээнд аюул, өртөнгө, эмзэг байдал, чадавхыг тооцон эрсдэлийг тодорхойлоход нийт 19 сумдын Өлзийт, Өгийнуур, Батцэнгэл, Чулуут, Төвшрүүлэх, Өндөр-Улаан, Хотонт, Эрдэнэмандал, Хашаат аюул их, бусад сумууд 54-өөс дээш аюул ихтэй, аймаг орон нутгийн 84.21% нь өртөх байдал ихтэй, эмзэг байдал нь аймгийн хэмжээнд маш их байна. Эрдэнэбулган, Хашаат, Өлзийт зэрэг

сумдын чадавх нь бусад сумуудаас харцайгүй сайн байгаа боловч аюул, өртөнгө, эмзэг байдал их байгаа нь эрсдэлийг нэмэгдүүлж байгаа тул, өртөнгө эмзэг байдлыг багасгах чадавхыг бэхжүүлэх ажлыг нэн тэргүүнд хийх шаардлагатай байна.

Тус ерөнхий үнэлгээний үр дүнгээс үзэхэд нэн түрүүнд:

- Объектын гал түймэр, Ой хээрийн түймэр, зуд, ган, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагаатай уялдуулан урьдчилан сэргийлэх ажил болон гамшгийн аюулыг даван туулах чадавхыг иргэнд бүрд ойлгуулах зорилгоор жилд 2-3 сургалтыг сум тус бүрд хүргэж дээрх дөрвөн аюулын хүрээнд хэрхэн өөрийгөө болон бусдыг хамгаалах чиглэлээр мэдлэг ойлголттой болгох.

- Гамшгийн төрөл бүрээр эрсдэлийн ерөнхий үнэлгээг зохион байгуулснаар цаашид тохиолдож болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх хохирол багатай даван туулахад ажлын үндсэн чиглэл болж өгнө.

- Архангай аймагт отор нүүдлээр ирж байгаа хөрш зэргэлдээ аймгуудаас ирж байгаа малчидтай гурвалсан гэрээг хийж оторлох сум багийг тусгайлан тогтоож өгөх.

- Чанаргүй малын тоог бууруулж малын тоо толгойг чанаржуулах бодлого баримтлах

- Сумдын ойн нөхөрлөлийн тоног төхөөрөмжийг шинэчилж, чадавхжуулах

### Санал

1. Эрсдэл өндөр байгаа тул бусад эрсдэл багатай аймгийн туршлагаас суралцаж ажиллуулах;

2. Эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх шаардлагатай;

3. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51.2 дах заалтын дагуу гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 1.0 хувиас доошгүй заавал эрсдэлийг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа хийж хэрэгжүүлэх саналтай байна.

### Ашигласан материал

Архангай аймгийн Онцгой байдлын байдлын газар. (2024). *Гамшиг осол, аюулт үзэгдлийн судалгаа (2019–2023)*. Архангай аймаг.

Баяржаргал, Б. (2012). *Гамшигийн эрсдэлийн үнэлгээний аргачлал*. Улаанбаатар.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн. (2023). *Архангай аймгийн гамшигийн эрсдэлийн үнэлгээний тайлан*. Улаанбаатар.

Саранцэцэг, Б. (2024). *Гамшигийн эрсдэлийн менежмент*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

1212.com. (2024, October 1). Retrieved from <https://www.1212.com>

